

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

болон

“ШИНЭ АЗИА ГРУПП” ХХК-ийн

хооронд байгуулсан

ТЭЛМЭНИЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН
СТАНЦ БАРИХ, АШИГЛАХ, ТӨРИЙН ӨМЧИД
ШИЛЖҮҮЛЭХ (ВОТ) ОНЦГОЙ ЭРХ ОЛГОХ
КОНЦЕССЫН ГЭРЭЭ

Улаанбаатар хот

2013 оны 06 сарын 28-ны өдөр

ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ

- 2.1.Нэр томъёог тайлбарлах
- 2.2.Гэрээг тайлбарлах, хэрэглэх

ГУРАВ.КОНЦЕССЫН ЗҮЙЛ, ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 3.1. Концессын зүйл
- 3.2. Концессын төрөл
- 3.3. Концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл
- 3.4. Концесс хэрэгжих нөхцөл
- 3.5. Концессын гэрээний хугацаа
- 3.6. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох
- 3.7. Концессын гэрээг сунгах
- 3.8. Концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
- 3.9. Концессын зүйлийг ашиглах концесс эзэмшигчийн онцгой эрх
- 3.10. Концесс эзэмшигчид хориглох зүйл
- 3.11. Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

ДӨРӨВ.ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1.Концесс олгогчийн эрх, үүрэг
- 4.2.Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

ТАВ.КОНЦЕСС ХЭРЭГЖИХТЭЙ ХОЛБООГОЙ БУСАД АСУУДАЛ

- 5.1.Газар ашиглуулах
- 5.2.Нүүрс хангалт
- 5.3.Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах ба үнэ тариф
- 5.4.Даатгал
- 5.5.Техникийн нөхцөл, үзүүлэлт
- 5.6.Санхүү, хөрөнгө оруулалт

ЗУРГАА.МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА

ДОЛОО.КОНЦЕССЫН ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 7.1.Концессын гэрээ дуусгавар болох
- 7.2.Концессын гэрээг цуцлах
- 7.3.Концессын гэрээг нэг талын санаачилгаар цуцлах
- 7.4.Гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөний улмаас гэрээ цуцлах
- 7.5.Давагдашгүй хүчин зүйл бий болсоны улмаас гэрээ цуцлах
- 7.6.Гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх
- 7.7.Концессын зүйлийг хүлээлгэн өгөх
- 7.8.Концессын зүйлийг үнэлэх, нөхөн олговрын хэмжээ тооцох

НАЙМ.ХАРИУЦЛАГА

ЕС.МАРГААН ШИЙДВЭРЛЭХ



АРАВ. БУСАД ЗҮЙЛС

- 10.1.Хууль хэрэглэх
- 10.2.Хууль тогтоомж өөрчлөгдөх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээ
- 10.3.Давагдашгүй хүчин зүйл
- 10.4.Давагдашгүй хүчин зүйл арилсаны үр дүнд авах арга хэмжээ
- 10.5.Нууц хадгалах
- 10.6.Мэдэгдэл хүргүүлэх
- 10.7.Бусад зүйл



УДИРТГАЛ

Монгол Улсын Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар тогтоол, 2011 оны 4 дугаар сарын 20-ны өдрийн 127 дугаар тогтоолыг тус тус үндэслэн:

НЭГ ТАЛААС:

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 156 дугаар тогтоолоор эрх олгосноор Эдийн засгийн хөгжлийн яам /цаашид “Концесс олгогч” гэх/-ыг төлөөлж Эдийн засгийн хөгжлийн сайд НЯМЖАВ овогтой БАТБАЯР:

НӨГӨӨ ТАЛААС:

Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгэгдсэн, Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, Шинэ Зууны байрт байрлах, 9019046051 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5305675 тоот регистрийн дугаар, 09-244 тоот гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ бүхий Монгол-Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай “Шинэ Азия групп” ХХК /цаашид “Концесс эзэмшигч” гэх/-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх олгосноор Ерөнхий захирал ЛХАМСҮРЭН овогтой ТӨРБАЯР нар:

дор дурьдсан нөхцөлийг харилцан тохиролцож, Монгол улсын Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт орших Могойн голын нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт Тэлмэний Дулааны Цахилгаан станц (цаашид “Цахилгаан станц” гэх) барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлтэй 2011 оны 5 дугаар сарын 11-ны өдөр байгуулсан Концессын гэрээ /цаашид “Гэрээ” гэх)-г шинэчлэн байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Гэрээний зорилго нь “Алтай-Улиастайн эрчим хүчний систем /АУЭХС/ болон Төвийн бүсийн эрчим хүчний систем /ТБЭХС/-д цахилгаан эрчим хүч нийлүүлэх, АУЭХС-ийг ТБЭХС-тэй холбосон ачаалал багатай шугамын реактив чадлыг балансжуулах, системийн горим ажиллагааг найдвартай тогтвортой ажиллуулах зориулалттай 100 МВт-ын хүчин чадал бүхий Цахилгаан станц барьж эрчим хүч үйлдвэрлэн ашиглах онцгой эрх эдлэх, концессын гэрээний хугацаа дуусахад Цахилгаан станцыг төрийн өмчид шилжүүлэн өгөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Концессыг хэрэгжүүлэхэд дор дурьдсан байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.1.1 Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах, концессын зүйлийг барьж байгуулах нөхцөлийг хангах, дэмжлэг үзүүлэх, .
 - 1.1.2 Концесс эзэмшигчийн боловсруулсан техник, эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт №1)-ийг хянаж, баталгаажуулах, Цахилгаан станцын барилга байгууламжийн угсралтын тусгай зөвшөөрлийг олгох, цахилгаан станцын барилга байгууламжийг барих, ашиглах, үйлдвэрлэл явуулах ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг нь зохицуулах;



- 1.1.3 Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн дагуу эрчим хүчний барилга байгууламж барьж байгуулах, цахилгаан үйлдвэрлэх, эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрлийг концесс эзэмшигчид олгож, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үнэ тарифыг хянаж батлах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;
- 1.1.4 Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлэх тусгай зөвшөөрөлийг олгож, Барилгын тухай хууль тогтоомжийн дагуу барилгын ажлын нөхцөл шаардлагыг хангуулж, хяналт тавих;
- 1.1.5 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-ийн 4.5.6 дугаар зүйлүүдэд заасны дагуу төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд дээрх хуулийн 7.8 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, шинжилгээ, хянан магадлагаа хийх.
- 1.3. Дараах дагалдах бусад гэрээнүүд нь энэ Гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:
- 1.3.1. энэ Гэрээний хавсралт №4: Нүүрс бэлтгэн нийлүүлж, худалдах, худалдан авах гэрээ;
- 1.3.2. энэ Гэрээний хавсралт №5: Газар ашиглах гэрээ;
- 1.3.3. энэ Гэрээний хавсралт №6: Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ;
- 1.3.4. энэ Гэрээний хавсралт №7: Ус ашиглах гэрээ;
- 1.3.5. энэ Гэрээний хавсралт №8: Концесс олгогч, концесс эзэмшигч, хөрөнгө оруулагч нарын хооронд байгуулсан төслийн санхүүжилтийн гэрээ;
- 1.3.6. энэ Гэрээний хавсралт №9: Хяналтын гэрээ
- 1.4. "Шинэ Азиа Групп" ХХК-ийн боловсруулж Эрчим хүчний салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн хурлаар батлуулсан Цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэл нь энэ Гэрээг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болно.
- 1.5. Техник, эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт №1)-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг эрчим хүчний салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.
- 1.6. Техник, эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт №1)-ээс үүдэн гарах аливаа хариуцлагыг Концесс олгогч хариуцахгүй болно.

ХОЁР.НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ

Нэр томъёог тайлбарлах

- 2.1. Энэхүү Гэрээнд дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:



- 2.1.17. **“Газар ашиглах гэрээ”** гэж концесс эзэмшигч, орон нутгийн газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан газар ашиглах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.2.2-т дурьдсан гэрээг;
- 2.1.18. **“Даатгал”** гэж энэ Гэрээний 5.4.1-т заасны дагуу концесс эзэмшигчийн заавал даатгуулах даатгалын төрлийг;
- 2.1.19. **“Дагалдах байгууламж”** гэж техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсарт №1)-ээр тодорхойлсон цахилгаан станцын эдэлбэр газар доторхи зам, гүүр, ус суваг, цэвэр бохир усны систем, далан хаалт, түлш, нүүрс дамжуулах хэрэгслэлийн инженерийн шугам сүлжээг;
- 2.1.20. **“Давагдашгүй хүчин зүйл”** гэж хохирогч талын санаатай, санамсаргүй үйлдэл, эс үйлдэлээс шалтгаалаагүй, урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан, энэ Гэрээний 10.3-т заасан улс төрийн ба улс төрийн бус, бусад нөхцөл байдал бий болсоныг;
- 2.1.21. **“Дагалдах бусад гэрээ”** гэж энэ Гэрээний нэгдүгээр бүлгийн ерөнхий нөхцөлийн 1.2-т дурьдсан гэрээг;
- 2.1.22. **“Цахилгаан станц”** гэж Техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлсон тус бүр нь 2х50 МВт-ын хүчин чадал бүхий Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт баригдах, нүүрсээр ажиллах дулааны цахилгаан станцыг;
- 2.1.23. **“Засвар, үйлчилгээний ажил”** гэж концессын зүйлийг ашиглалтын явцад техникийн стандарт, норм, нормативын дагуу засварлах, засан сайжруулах, сэргээн засварлах, их засвар, үйлчилгээг;
- 2.1.24. **“кВт”** гэдэгт киловаттыг;
- 2.1.25. **“кВтхц”** гэдэгт киловатт цагийг;
- 2.1.26. **“Концесс олгогч”** гэж Эдийн засгийн хөгжлийн яамыг;
- 2.1.27. **“Концесс эзэмшигч”** гэж концесс авсан “Шинэ азиа групп” ХХК-ийг;
- 2.1.28. **“Концесс”** гэж концесс олгогчоос концесс эзэмшигчид олгож буй энэ Гэрээний 1.1-д заасан онцгой эрхийг;
- 2.1.29. **“Барих-ашиглах-шилжүүлэх концессын төрөл”** гэж Концессын тухай Монгол улсын хуулийн 4.1.1 дүгээр зүйлд тодорхойлсоноор концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх энэ Гэрээний төрлийг;
- 2.1.30. **“Концессын гэрээг байгуулсан өдөр”** гэж энэ Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрийг;
- 2.1.31. **“Концессын гэрээний хугацаа”** гэж энэ Гэрээний 3.6.1-д заасан хугацааг;
- 2.1.32. **“Концессын гэрээ хэрэгжиж эхлэх өдөр”** гэж энэ Гэрээний 3.3, 3.4-д заасан гэрээ хэрэгжих урьдчилсан болон шаардлагатай бусад нөхцөл бүрдэж, концесс эзэмшигч төслийн гүйцэтгэгчийн хооронд байгуулсан энэ Гэрээний хавсралтаар баталсан барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөний дагуу барилгын ажил хийгдэж эхэлсэн өдрийг;
- 2.1.33. **“Концессын зүйл”** гэж энэ Гэрээний 3.1.1, 3.1.2-т тодорхойлсныг;
- 2.1.34. **“Концессын зүйлийг бүрэн шилжүүлж хүлээлгэн өгөх хугацаа”** гэж энэ Гэрээний 7.7.2-т заасан өдрийг;
- 2.1.35. **“Концессын зүйлийг хүлээлцэх комисс** гэж Гэрээний 7.7.1-т заасан үүрэг бүхий комиссыг;
- 2.1.36. **“Концессын зүйлийг ашиглах”** гэж энэ Гэрээний 3.11-т заасан нөхцөлөөр концессын зүйлийг ашиглахыг;



- 2.1.1. **“Ажлын өдөр”** гэж долоо хоногийн Бямба, Ням гариг, Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон нийтээр амрах баяр, ёслолын өдрөөс бусад ажлын өдрийг;
- 2.1.2. **“Ажиллах хүч”** гэж Концессын зүйлийг барьж байгуулах, ашиглах явцад концесс эзэмшигч болон цахилгаан станцын ашиглалтыг хэрэгжүүлэгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуул, ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн болон гэрээт ажиллагсадыг;
- 2.1.3. **“Ам.доллар”** гэж Америкийн нэгдсэн улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;
- 2.1.4. **“АУЭХС ТӨХК”** гэж “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийг;
- 2.1.5. **“Ашиглалтад оруулах, хугацаа”** гэж энэ Гэрээний 3.4.1.7)-д заасны дагуу цахилгаан станцын барилга байгууламжийг бүрэн барьж дуусгаж, хэвийн, найдвартай ажиллагааг жигдрүүлж, шалгаж, туршилт хийснээр комисс дүгнэлт гаргаж баталгаажуулах хугацааг;
- 2.1.6. **“Барилга, байгууламж”** гэж “Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасныг;
- 2.1.7. **“Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”** гэж Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн 151 дүгээр тогтоолоор батлагдсан барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтад оруулах дүрмийг;
- 2.1.8. **“Барилгын ажлын зураг төсөл”** гэж “Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасныг;
- 2.1.9. **“Барилгын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”** гэж Барилгын тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу концесс эзэмшигчид олгох тусгай зөвшөөрлийг;
- 2.1.10. **“Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөө”** гэж зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрт хийгдэх ажлын технологийн дараалал, хуваарийг;
- 2.1.11. **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”** гэж “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 3.1.1-д заасныг;
- 2.1.12. **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”** гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу эрх бүхий байгуулагаас гаргасан гэрээний хавсралт №1-д хавсаргасан нарийвчилсан үнэлгээг;
- 2.1.13. **“Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”** гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг багасгах, арилгахад чиглэсэн концесс эзэмшигчээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан ажлын төлөвлөгөөг;
- 2.1.14. **“Барилгын техникийн нөхцөл”** гэж Барилгын тухай хуулийн 3.1.7-д заасныг;
- 2.1.15. **“Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг”** гэдэгт цахилгааны нийлүүлэлтийн хэмжээг бүртгэх зориулалт бүхий тооцооны болон хяналтын тоолуур суурилагдсан холболтын шугамыг цахилгаан дамжуулах шугамтай холбож буй цэгийг;
- 2.1.16. **“Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, арилжаалж эхлэх өдөр”** гэдэгт цахилгаан үйлдвэрлэх 2 генераторын эхний генераторт туршилт тохируулга хийгдэж 72 цагийн турш бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж иж бүрэн ашиглалтад оруулан, комиссоор хүлээлгэн өгсөн өдрийг;



- 2.1.37. **“Концессын зүйлийн үр шим”** гэж концессын зүйлийг эзэмших ашиглах явцад түүнийг зориулалтын дагуу ашигласнаас бий болсон бүтээгдэхүүн, орлогыг;
- 2.1.38. **“МВт”** гэдэгт мегаваттыг;
- 2.1.39. **“Нийлүүлсэн цахилгаан”** гэж концесс эзэмшигчийн үйлдвэрлэж, бүтээгдэхүүн арилжаалах цэгт нийлүүлсэн, КВт×ц-аар илэрхийлэгдсэн цахилгааны хэмжээг;
- 2.1.40. **“Нийтийн зориулалттай дэд бүтэц, үйлчилгээг ашиглуулах”** гэж концессын гэрээний хэрэгжих хугацаанд төслийн санхүүжилт болон концесс эзэмшигчийн орлого, ашгаас барьж байгуулсан зам, гүүр, холбоо, далан, суваг, инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууц, нийтийн үйлчилгээ, худаг ус, ногоон байгууламж зэрэг дагалдах байгууламжийг цахилгаан станцын хамт олон болон олон нийтэд төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулахыг;
- 2.1.41. **“Нүүрс”** гэж нүүрсний уурхайгаас олборлож, цахилгаан станцад эрчим хүчний эх үүсвэр болгож ашиглах эрчим хүчний нөөцийг;
- 2.1.42. **“Нүүрс бэлтгэн нийлүүлж, худалдах худалдан авах гэрээ”** гэж концесс эзэмшигч, нүүрсний уурхайн хооронд байгуулсан нүүрсээр хангах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.3.1-д дурьдсан гэрээг;
- 2.1.43. **“Татвар”** гэж Татварын тухай Монгол улсын хуулийн хүрээнд концесс эзэмшигчийн төлөх бүх төрлийн албан татвар, хураамж, төлбөрийг;
- 2.1.44. **“Комисс”** гэж Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах комиссыг;
- 2.1.45. **“Техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх)”** гэж энэ Гэрээний хавсралт №1-ээр тодорхойлж, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар баталсан, цахилгаан станц барих, ашиглах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх техникийн нөхцөл, эдийн засгийн тооцоо, төлөвлөлт, судалгааг агуулсан баримт бичгийг;
- 2.1.46. **“Төсөл”** гэж концессын гэрээний хүчинтэй хугацаанд хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг;
- 2.1.47. **“Барилгын ажлын гүйцэтгэгчийн гэрээ”** гэж концесс эзэмшигч төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг;
- 2.1.48. **“Ус ашиглах гэрээ”** гэж концесс эзэмшигч, орон нутгийн усны асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан усны нөөц ашиглах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.3.4-т дурьдсан гэрээг;
- 2.1.49. **“Усны нөөц”** гэж станцад ашиглах гадаргын болон газрын хөрсөн доорхи усыг;
- 2.1.50. **“Гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл”** гэж энэ Гэрээний 3.3-т заасан нөхцөлийг;
- 2.1.51. **“Үйлдвэрлэл явуулах хугацаа”** гэж концессын зүйлийг ашиглалтад оруулсан өдрөөс эхлэн концесс олгогчид бүрэн хүлээлгэн өгөх хүртэлхи хугацаанд концесс эзэмшигч цахилгаан станцыг удирдан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хугацааг;
- 2.1.52. **“Концесс эзэмшигчтэй холбогдох этгээд”** гэж концесс эзэмшигчийн болон түүний толгой компаний хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг иргэн, хуулийн этгээдийг;

- 2.1.53. “Хохирогч тал” гэж давагдашгүй хүчин зүйл, гэрээний эрх зөрчигдсөний улмаас энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, эсхүл эрх ашиг нь зөрчигдсөн талыг;
- 2.1.54. “Хөрөнгө оруулагч” гэж концесс эзэмшигчтэй хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ байгуулсан этгээдийг;
- 2.1.55. “Төслийн санхүүжилтийн гэрээ “цаашид Санхүүжилтийн гэрээ” гэх” гэж концесс олгогч, концесс эзэмшигч, хөрөнгө оруулагч нарын хооронд байгуулсан гэрээг;
- 2.1.56. “Хуанлийн жил” гэж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг;
- 2.1.57. “Хуанлийн улирал” гэж жилийн дараалсан 3 сар буюу (I) 1, 2, 3 дугаар сар, (II) 4, 5, 6 дугаар сар, (III) 7, 8, 9 дүгээр сар, (IV) 10, 11, 12 дугаар сарыг;
- 2.1.58. “Хуанлийн сар” гэдэгт хуанлийн 12 сарын аль нэг сарыг;
- 2.1.59. “Хэмжих хэрэгсэл” гэж тооцооны болон хяналтын тоолуурыг хамтад;
- 2.1.60. “Хяналтын багц” гэж концесс эзэмшигчийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг;
- 2.1.61. “Цахилгаан” гэж цахилгаан станцын барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах хугацаанд концесс эзэмшигчийн төвийн эрчим хүчний эх үүсвэрээс гэрээний дагуу авч ашиглах, үйлдвэрлэл явуулах хугацаанд станц өөрөө үйлдвэрлэж, нийлүүлэх цахилгаан эрчим хүчийг;
- 2.1.62. “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” гэж концесс эзэмшигч, цахилгаан эрчим хүч нийлүүлэх, авах эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан цахилгаан эрчим хүч нийлүүлэх, худалдан авах нөхцөл журмыг тохиролцсон гэрээг, цаашид худалдан авагчидтай байгуулах гэрээг;
- 2.1.63. “Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл” гэж Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Эрчим хүчний зохицуулах газраас эрчим хүчний барилга байгууламж барих ажлыг гүйцэтгүүлэх эрхийг хууль тогтоомжоор тавигдсан шаардлагыг хангасан төслийн гүйцэтгэгчээр ажиллах этгээдэд олгох тусгай зөвшөөрлийг;

Гэрээг тайлбарлах, хэрэглэх

- 2.2. Гэрээг дор дурьдсан зарчмын дагуу тайлбарлаж, хэрэглэнэ:
- 2.2.1. Гэрээний бүлэг, зүйл, заалтад тэдгээрийг хэрэглэхэд ойлгомжтой болгох зорилгоор гарчиг өгч нэрлэсэн нэр нь гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй.
- 2.2.2. Нэг тоогоор олон тоог, олон тоогоор нэг тоог төлөөлүүлэн хэрэглэсэн тохиолдолд хэрэглэсэн тооны утгаар нь ойлгоно.
- 2.2.3. Гэрээнд дурдагдсан, ишлэл хийсэн хууль, тогтоол, тушаал, захирамж, удирдамж, аргачлал, адилтгах эрх зүйн баримт бичигт тэдгээрийн шинэчилсэн найруулга, оруулсан нэмэлт өөрчлөлтийг хамааруулан ойлгоно.
- 2.2.4. Энэ Гэрээ, түүний хавсралтад оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг гэрээ болон хавсралтад хамруулан хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг гэж ойлгож хэрэглэнэ.
- 2.2.5. Гэрээнд тусгайлан заагаагүй бол нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн техникийн болон худалдааны үг хэллэгийг нийтээр хүлээн зөвшөөрч хэрэглэдэг утгаар нь ойлгоно.

ГУРАВ. КОНЦЕССЫН ЗҮЙЛ, ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

3.1. Концессын зүйл

- 3.1.1. Концессын гэрээг хэрэгжүүлэх зорилгоор олгосон газар, концесс эзэмшигчийн оорийн болон оорийн боломжоор олж авсан хороонгоор Цахилгаан станц барьж, ашиглахад оруулах цахилгаан станц, түүний бүрдэл хэсэг, дагалдах байгууламж, гэдгээрийн омчлох эрх, концессын зүйлийг ашиглах явцад цахилгаан станцын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүнийг худалдан борлуулсаны орлого, цахилгаан станцын дагалдах байгууламжийг бусдад ашиглуулсанаас олсон орлого, ашиг, үр шим, оюуны омч нь концессын зүйл байна.
- 3.1.2. Барилга байгууламжийн зураг төсөл, цахилгаан станцын технологийн баримт бичиг, ашиглалтын зааварчилгаа, ноу хау нь концессын зүйлд хамаарна.
- 3.1.3. Цахилгаан станцын бүрдэл хэсэг, дагалдах байгууламжийн үндсэн тоноглол, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний дэлгэрэнгүй зураглал, холболтын схем, гэдгээрийн технологийн шийдэл, техникийн үзүүлэлтийг техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт №1)-ээр тодорхойлно.

3.2. Концессын төрөл

- 3.2.1. Энэ Гэрээний дагуу хэрэгжүүлэх концесс нь Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 102 дахь хэсэгт зааснаар БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ концессын төрөлд хамаарна.

3.3. Концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл

- 3.3.1. Энэ гэрээг хэрэгжүүлэхэд урьдчилан хангах зайлшгүй шаардлагатай дор дурьдсан нөхцөлүүдийг концесс эзэмшигч нь энэ Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 60 хоногийн дотор концесс олгогчид ирүүлж гэрээнд хавсаргасан байна. Үүнд:
 - 1) энэ Гэрээний 1.3.1-1.3.6-д дурьдсан дагалдах бусад гэрээнүүдийг шинэчлэн байгуулсан гэрээний эх хувь;
 - 2) байгаль орчны нөлөөлөл байдлын нарийвчилсан үнэлгээг Байгаль орчны тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу хийлгэж, эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулсан эх хувь (энэ Гэрээний хавсралт №10);
 - 3) цахилгаан станцын зураг төслийн магадлалыг барилга угсралтын ажил эхлэхээс өмнө Барилгын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагаар хийлгэж, баталгаажуулсан эх хувь (энэ Гэрээний хавсралт №11)
 - 4) үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Могойн голын уурхайн удирдлага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран нүүрсний ордны нөөц хангалтыг сайжруулах нарийвчилсан төлөвлөгөөг баталсан эх хувь (энэ Гэрээний хавсралт №12);
 - 5) дараахи тусгай зөвшөөрлүүдийг Эрчим хүчний тухай болон Барилгын тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу эрх бүхий байгууллагуудаас авсан байна:

- 1/ эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл;
- 2/ эрчим хүчний угсралтын болон барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл;
- 3) барилгын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл.

3.4. Концессын гэрээ хэрэгжих нөхцөл

3.4.1. Энэ Гэрээ нь дор дурьдсан нөхцөлийн дагуу хэрэгжинэ:

- 1) Техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт №1)-ийн дагуу энэхүү төслийг хэрэгжүүлэх ба уг баримт бичиг нь энэ Гэрээний хамт төслийн үндсэн баримт бичиг болно;
- 2) Концессын зүйлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, хянуулах, батлуулах, барилгын материал, техник, тоног төхөөрөмж, цахилгаан станцын тоноглол, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг худалдан авах, суурилуулах, угсрах, турших, ашиглалтад оруулах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, үйлдвэрийн ашиглалтын явцын засвар, үйлчилгээний зардал болон үндсэн ба туслах тоног төхөөрөмжийн их завсар, шинэчлэлийг концесс эзэмшигч хариуцаж, эдгээрт шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ;
- 3) Концессын төслийн төсөвт өртөгийн дээд хэмжээ 183 сая 390 мянган (нэг зуун наян гурван сая гурван зуун ерөн мянган) ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс ихгүй байна. Төсөвт өртөгийн хэмжээ өөрчлөгдөх нөхцөл байдал үүсвэл талууд шалтгаан, үндэслэлийг хэлэлцэж, Монгол улсын Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ;
- 4) Санхүүжилтийн хэмжээ, нөхцөл, хуваарийг энэ Гэрээний 5.6 дахь заалт болон төслийн Санхүүжилтийн гэрээ (энэ Гэрээний хавсралт №8)-ний дагуу тогтооно;
- 5) Санхүүжилтийн гэрээг Концессын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу байгуулна. Санхүүжилтийн гэрээнд энэ Гэрээний дагуу шаардагдах хөрөнгө оруулалтын нөхцөл, стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэгчийн эрх, үүрэг, концесс эзэмшигчийг өөрчлөх нөхцөл, журмыг нарийвчлан тодорхойлно;
- 6) Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна;
- 7) Цахилгаан станцын эхний ээлжийн нэг турбин нэг зуухыг /50 МВт/ 2014 оны 12 дугаар сарын дотор барьж, ашиглалтад оруулна;
- 8) Концесс эзэмшигч нь төслийг хэрэгжүүлэх цорын ганц зорилгоор тусгай зориулалттай "Тэлмэний ДЦС" оноосон нэртэй охин компани байгуулж, уг компани нь гэрээний хугацаанд төсөлтэй холбоогүй өөр бусад төсөл болон бизнесийн үйл ажиллагаа эрхлэхгүй болно.



3.5. Концессын гэрээний хугацаа

3.5.1. Концессын гэрээний хугацаа 22 жил байна.

3.5.2. Концессын гэрээний хугацаа нь энэ гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж, концессын гэрээний хугацаа дуусах хүртэл, эсхүл концесс олгогч болон түүний эрх олгосон этгээдэд концессын зүйлийг хүлээлгэн өгөх нөхцөл бий болсоноор концессын зүйлийг шилжүүлж, хүлээлгэн өгч дуусах өдөр хүртэл үргэлжилнэ.

3.6. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох

3.6.1. Энэ Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсанаар уг гэрээний талууд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрх, хууль ёсны итгэмжлэлтэй болохоо харилцан баталгаажуулсанд тооцно.

3.6.2. Энэ гэрээний 3.3-т заасан концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдсанаар энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсонд тооцно.

3.7. Концессын гэрээг сунгах

3.7.1. Энэ Гэрээний 3.6.1-д заасан Гэрээний хугацааг зөвхөн дараах тохиолдолд сунгаж болно:

- 1) төрийн байгууллагаас гаргасан шийдвэрээс шалтгаалж, концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон бол тухайн хугацаагаар;
- 2) гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр концессын гэрээнд заасан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болсноор энэ Гэрээний хугацаа тасалдсан, хойшлогдсон боловч тухайн нөхцөл байдал арилсанаар гэрээ хэрэгжих боломжтой болсон бол тасалдсан, хойшлогдсон хугацаагаар;
- 3) энэ гэрээнд тусгагдаагүй нөхцөл шаардлагыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээд нэмж шаардсаны улмаас концессын төсөвт өртөг нэмэгдэх болсон, энэхүү нөхцөл байдал үүссэний улмаас шаардагдаж буй нэмэгдэл санхүүгийн эх үүсвэрийг концесс олгогч гаргах боломжгүй байгаа, концесс эзэмшигч гэрээний хугацааг сунгалгүйгээр тухайн зардлыг олох, нөхөх боломжгүй бол хөрөнгө олох боломжит хугацаагаар;

3.7.2. Концессын гэрээний хугацаанд концесс эзэмшигч өөрийн буруутай үйл ажиллагаанаас концессын санхүүжилтийг нөхөх хэмжээний ашигтай ажиллаж чадаагүй нь энэ гэрээг сунгах үндэслэл болохгүй.

3.7.3. Цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлд тооцоологдсон үнэ нь эрчим хүчний тухай хуулийн дагуу үнэ бүрэн чөлөөлөгдсөн, өөрчлөгдсөн тохиолдолд концесс олгогч, концесс эзэмшигч талууд энэ Гэрээний 3.6.1-д заасан хугацаанд өөрчлөлт оруулж багасгаж болно.

3.8. Концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.8.1. Талууд харилцан тохиролцож, энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3.8.2. Концесс эзэмшигч Концессын тухай Монгол улсын хуулийн 23.2, 23.3 дугаар зүйлд заасны дагуу гэрээний нөхцөлийг өөрчлөх санал гаргах эрхтэй.

3.8.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд талууд дараахи журмыг баримтлана:



- 1) нэмэлт өөрчлөлт оруулах мэдэгдэл, саналаа тусгасан гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй өдрөөс хуанлийн 30-аас доошгүй хоногийн дотор санал гаргагч тал нөгөө талдаа бичгээр, биечлэн эсхүл албан ёсны харилцаандаа хэрэглэж заншсан холбоо харилцааны хэрэгслээр хүргүүлж, энэ талаар нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээдэд заавал мэдэгдэнэ.
 - 2) мэдэгдэл, санал хүргүүлсэнээс хойш хуанлийн 30 хоногийн дотор саналыг хүлээн авсан тал саналыг зөвшөөрч, эс зөвшөөрч байгаа эсэх талаараа хариу мэдэгдэл, саналыг энэ хэсгийн 1-д заасны дагуу буцаан хүргүүлнэ.
- 3.8.4. Талууд санал нэгдсэн тохиолдолд энэ Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг үйлдэж, гарын үсэг зурж, баталгаажуулсанаар мөрдөж эхэлнэ.
- 3.8.5. Мэдэгдэл, саналын дагуу талууд өөр байр суурьтай байгаа тохиолдолд санал гаргасан тал уулзалт зохион байгуулж, энэ талаар харилцан зөвшилцөлд хүрэх шаардлагатай бүхий л арга хэмжээг хамтарч авна.
- 3.8.6. Талууд тохиролцоонд хүрч эс чадвал санал гаргагч тал тавьсан саналаа хэвээр үлдээх, аль эсхүл уг саналаасаа татгалзах талаар өөрийн байр суурийг нөгөө талдаа дахин бичгээр хүргүүлнэ.
- 3.8.7. Энэ Гэрээний 3.8.6-д заасан нөхцөл бий болсоноор талуудад Гэрээг цуцлах санал гаргах эрх үүснэ.

3.9. Концессын зүйлийг эзэмших концесс эзэмшигчийн онцгой эрх

- 3.9.1. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг концессын гэрээний хугацаанд ашиглана.
- 3.9.2. Концесс эзэмшигч нь концессын гэрээний хугацаанд энэ Гэрээний 3.1.1, 3.1.2-т заасан концессын зүйлээс бусад эд хөрөнгө, орлого, олсон ашиг ашиг, үр шим нь концесс эзэмшигчийн өмч байна.
- 3.9.3. Концессын зүйлийг ашиглах явцад цахилгаан станц, түүний бүрдэл хэсэг, дагалдах байгууламжуудийг бүхэлд нь мэдэлдээ байлгаж, удирдлагыг хэрэгжүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу худалдан борлуулах, түүнчлэн дагалдах зүйлсийг олон нийтэд болон гуравдагч этгээдэд төлбөртэй, төлбөргүйгээр ашиглуулах, түрээслэх зэргээр захиран зарцуулж орлого олох, бараа, материал, тоног төхөөрөмж, станцын зураг төслийн эх зохиол, оюуны өмч, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг концесс эзэмшигчийн нэр дээр бүртгэж өмчлөх, үйлдвэрийн цэвэр ашгаас хүртэх эрхтэй байна.
- 3.9.4. Концессын зүйлийн дагалдах байгууламжийг нэмэгдэл орлого олох зорилгоор олон нийтэд ашиглуулахдаа үнэ тариф болон нөхцөлийг концесс эзэмшигч тогтоох эрхтэй байна.
- 3.9.5. Концессын зүйлийг барьж байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтыг олох, бий болсон концессын зүйлийг хэвийн ажиллуулах, өргөжүүлэх, хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг олоход концессын зүйлийг барьцаалах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд концесс олгогчийн зөвшөөрсөнөөр шийдвэрлэнэ.
- 3.9.6. Концессын зүйлийн оюуны өмчийн болон концессын зориулалтаар эзэмшүүлж буй газрыг ашиглах эрхийг барьцаалах эрх үүнд нэгэн адил хамаарна.



- 3.9.7. Концессын зүйлийн оюуны өмч болон цахилгаан станц, түүний дагалдах байгууламжийн зураг төсөл, технологийн баримт бичиг, ашиглалтын зааварчилгаа, ноу-хау, бусад оюуны өмч нь концессын зүйлийг төрд шилжүүлэх хүртлэх хугацаанд концесс эзэмшигчийн өмчлөлд байна.
- 3.9.8. Концесс эзэмшигч нь концессын гэрээний хугацаа дуусахад концессын зүйлийг бүхэлд нь төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

3.10. Концесс эзэмшигчид хориглох зүйл

- 3.10.1. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг бэлэглэх, арилжих, худалдах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 3.10.2. Концесс эзэмшигч энэ Гэрээний дагуу эдлэх эрх, хүлээх үүргээ концесс олгогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэх, гэрээ хэлцэл хийхийг хориглоно. Үүнд:
- 1) концессын зүйлийг санхүүжүүлэх зорилгоор барьцаалах;
 - 2) хяналтын багцаа худалдах, барьцаалах, концессын зүйлийг удирдах, эзэмших эрх, үүргийг холбогдох болон гуравдагч этгээдэд шилжүүлэх;
 - 3) хяналтын багцаа алдах хэмжээнд өөрчлөн зохион байгуулагдах замаар эрх, үүргээ шилжүүлэх;
 - 4) хувьцаат компани болох, хувьцаагаа зах зээлд худалдах, үнэт цаас гаргах, арилжаалах;
 - 5) хөрөнгө оруулагч өөрчилж, гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах;
 - 6) энэ гэрээгээр тохиролцсон болон техник эдийн засгийн үндэслэлийн дагуу гүйцэтгэх ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр тасалдуулах, өөр этгээдээр гүйцэтгүүлэх.
- 3.10.3. Концессын зүйлийг бусдад шилжүүлэхдээ энэ Гэрээний 3.10.2, 3.11.4 дүгээр зүйл болон Концессын тухай Монгол улсын хуулийн 27, 32 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 3.10.4. Зөвхөн дор дурьдсан тохиолдолд концесс эзэмшигчийн энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг гуравдагч этгээдэд буюу концесс олгогчийн мэдэлд шилжүүлнэ:
- 1) аль нэг талын санаачилгаар, эсхүл гэрээний үүрэг зөрчигдсөнөөс концессын гэрээ цуцлагдаж, концесс олгогч өөр концесс эзэмшигчийг сонгож гэрээ байгуулсан тохиолдолд шинэ концесс эзэмшигчид;
 - 2) Концессын тухай Монгол улсын хуулийн 32.3 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын улмаас концесс олгогч өөртөө түр шилжүүлэн авахад.

3.11. Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

- 3.11.1. Энэ Гэрээний хэрэгжилтэд концесс олгогч болон энэ Гэрээний ерөнхий зүйлд заагдсан зохицуулах байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 3.11.2. Энэ Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө биелэгдсэн байх гэрээний урьдчилсан нөхцөлийг хангасан тухай концесс эзэмшигч концесс олгогчид албан ёсоор ирүүлэх ба концесс олгогч түүнийг хянан үзэж хүлээн авсанаар энэ Гэрээг хүчин төгөлдөрт тооцно.
- 3.11.3. Концесс олгогч төслийн хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн өндөр үр чадвартай итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажилуулах ба концесс



эзэмшигчтэй хяналтын гэрээ (энэ Гэрээний хавсралт №9) байгуулж ажиллана. Хяналт тавих итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ажлын хуваарь, хийгдэх ажлын төлөвлөгөө, тайлагнах хугацааг концесс эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр боловсруулж концесс олгогчоор батлуулан ажлын удирдлага болгон ажиллана. Энэ Гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын зардлын хэмжээг хяналтын гэрээ (энэ Гэрээний хавсралт №9)-нд тусгах ба энэ зардлыг концесс эзэмшигч санхүүжүүлнэ.

- 3.11.4. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгохдоо Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь концесс эзэмшигч техник эдийн засгийн үндэслэлд заасан технологийн шаардлагыг хангах үндсэн болон туслах өмнө ашиглагдаж байгаагүй, ашиглалтаас хасагдаагүй, цаашид удаан жил хэвийн ажиллах боломжтой техник тоног төхөөрөмжийг сонгож чадсан эсэх, хөрөнгө оруулалт, орлого, зарлага, үр ашгийн тооцоо нь үндэслэлтэй хийгдсэн эсэх, санхүүгийн чадавхитай, боловсон хүчин, ажлын дадлага хангалттай байгаа эсэхийг нарийн шалгаж, зөвшөөрөл олгох ба тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэд тухайн байгууллага хяналт тавьж, эдгээр нөхцөл шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага хүлээлгэж ажиллана.
- 3.11.5. Барилгын ажил үйлчилгээ эрхлэх, эрчим хүчний барилга угсралт барих тусгай зөвшөөрлийг төслийн гүйцэтгэгчид олгохдоо Барилгын асуудал эрхэлсэн болон Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон харьяа байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд концесс эзэмшигчид хууль тогтоомжийн шаардлага, шалгуурт нийцсэн зураг төсөл, техникийн нөхцөл, шаардлагаар ажиллах эсэх, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, нормативын шаардлагыг хэрхэн хангаж байгааг шалгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.
- 3.11.6. ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт №1)-д тусгагдсан техник, технологийн болон бусад нөхцөлийн хэрэгжилтэд Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.
- 3.11.7. Барилга байгууламжийн зураг төсөл нь Барилгын тухай, Эрчим хүчний тухай Монгол улсын хууль тогтоомж, стандартад нийцсэн эсэхэд эрчим хүчний болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.
- 3.11.8. Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийг турших, хэвийн ажиллагааг жигдрүүлэх цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон техникийн нөхцөл, шаардлага, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, нормативыг техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд Эрчим хүчний болон Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон тэдгээрийн харьяа байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж ажиллана.
- 3.11.9. Энэ гэрээгээр концесс эзэмшигч хийхээр тохирсон ажил үйлчилгээг холбогдох Монгол улсын хууль тогтоомж, техник эдийн засгийн үндэслэлд заасан нөхцөл шаардлагын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэгдэж байгаа эсэх, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилт хуваарийн дагуу хэвийн хийгдэж байгаа эсэхэд концесс олгогч хяналт тавина. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн аудитын байгууллагаар үнэлгээ, дүгнэлт гаргуулж болно.

- 3.11.10. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний орон нутаг дахь салбар байгууллагууд хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.
- 3.11.11. Цахилгаан станцыг ашиглалтад оруулах үед цахилгаан станцын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн авна.
- 3.11.12. Цахилгаан станцын ашиглалт, үйлдвэрлэлийн явцад Эрчим хүчний тухай хууль тогтоомж, тогтоосон дүрэм, журмыг баримтлан ажиллаж байгаа эсэхэд Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.
- 3.11.13. Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх үнэ тарифыг Эрчим хүчний тухай хууль тогтоомжид заасан аргачлал, журмын дагуу эрчим хүчний үнэ тариф, зохицуулалт хариуцсан зохицуулах байгууллага баталж, биелэлтэд хяналт тавина.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Концесс олгогчийн эрх, үүрэг

4.1.1. Концесс олгогч Концессын тухай Монгол улсын хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараахи эрх эдэлнэ:

- 1) энэ Гэрээгээр тохиролцсон, ТЭЗҮ-д тусгагдсан техник, технологи, хүчин чадал бүхий ДЦС-ыг барьж ашиглахыг концесс эзэмшигчээс шаардах;
- 2) хууль буюу энэ Гэрээнд заасан үндэслэлээр энэ Гэрээг цуцлах, концесс эзэмшигчийн эрх, үүргийг түр шилжүүлэн авах, концесс эзэмшигчийг өөрчлөх, концессын зүйлийг шилжүүлэн авах;
- 3) концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих явцад шаардлагатай гэж үзвэл концесс олгогч болон эрх бүхий байгууллага олон улсын болон дотоодын мэргэжлийн шинжээчийн багаар хөндлөнгийн, мэргэжлийн дүгнэлт гаргуулах, түүнтэй холбогдох зардлыг концесс эзэмшигчээс гаргахыг шаардах;
- 4) концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл болон энэ гэрээнд заасан бусад нөхцөлийг хангуулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
- 5) цахилгаан станцын техник, тоног төхөөрөмж, материалын чанар, технологийн үзүүлэлтэд олон улсын болон Монголын холбогдох стандарт, норм хэмжээг хангасан байхыг шаардах, шаардлага хангаагүй техник, тоног төхөөрөмж, материал ашиглахыг хориглох;
- 6) хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх шаардлагатай гэж концесс эзэмшигч үзсэн тохиолдолд нэмэгдэх болсон шалтгаан, үндэслэлийг концесс эзэмшигчээр тухай бүр гаргуулж авах, хянан үзэж Засгийн газарт таницуулан шийдвэрлүүлэх;
- 7) энэ Гэрээний 3.11 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээ хэлцлийг хүчингүй болгохыг шаардах, хүчингүй болгуулахаар хуулийн байгууллагад хандах;
- 8) энэ Гэрээний биелэлтэд хяналт тавих зорилгоор өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хяналтын гэрээ (энэ Гэрээний



хавсралт №9)-ний дагуу концесс эзэмшигчийн зардлаар томилон ажиллуулах;

- 9) цахилгаан станцыг төрд хүлээлгэн өгөх үед станцын үндсэн болон туслах тоноглол, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн ашиглалт, угсралтын баримт бичиг, заавар, зааварчилгаа, ноу хауг хувилж авах, түүнчлэн концессын зүйлийг хүлээн авах үед тэдгээрийг эх хувиар нь нууцлалын кодын хамт бүрэн шилжүүлж авах;
- 10) концессын зүйлийг энэ Гэрээний 5.4-т заасан даатгалд заавал даатгуулахыг шаардах;
- 11) барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөнд тусгасан хуваарийг зөрчигдсөн тохиолдолд шалтгааныг тодруулах, цаашид хуваарийн дагуу хийж гүйцэтгэх талаар зөвлөх, сануулах, зөрчигдсөн шалтгааныг арилгах, шийдлийг олоход концесс эзэмшигчтэй хамтран ажиллах.

4.1.2. Концесс олгогч дараахь үүрэг хүлээнэ:

- 1) концесс эзэмшигчийн буруугаас энэ гэрээг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болон гэрээг хэрэгжүүлэх бусад нөхцөлийг хугацаанд нь хэрэгжүүлж чадаагүй, станц, дагалдах байгууламжийг барих ажлыг хуваарь зөрчигдсөн зэрэг нь энэ гэрээг цуцлах хэмжээний зөрчил биш гэж үзсэн тохиолдолд концесс эзэмшигчид сануулах, энэ Гэрээний 8.1-д заасан хариуцлага ногдуулах, тодорхой үүрэг өгөх;
- 2) нүүрсний үнийг тогтвортой байлгах, цахилгаан станц барьж байгуулах явцад төвийн эрчим хүчнээс цахилгаан худалдан авч ашиглах нөхцөлд үнийг тогтвортой байлгах чиглэлээр зохицуулах байгууллагууд болон орон нутгийн эрх бүхий байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;
- 3) төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглалтад оруулах ажиллагааг цаг хугацаанд нь гүйцэтгүүлэхийн тулд Концессын тухай Монгол улсын хуулийн 21.1.8, 30.1.3 дугаар зүйлд заасан дэмжлэгийг концесс эзэмшигчид үзүүлэх, эдгээртэй холбоотой УИХ, Засгийн газраас шийдвэрлэх асуудлыг богино хугацаанд шийдүүлэх талаар санал хүргүүлэх;
- 4) дагалдах бусад гэрээг хэрэгжүүлэхэд концесс эзэмшигчид дэмжлэг үзүүлж, шаардлагатай тохиолдолд Засгийн газарт танилцуулан холбогдох шийдвэр гаргуулах;
- 5) энэ Гэрээний 3.8-д заасны дагуу концессын гэрээг сунгах нөхцөл үүссэн тохиолдолд Засгийн газарт танилцуулан холбогдох шийдвэр гаргуулах;
- 6) концесс хэрэгжих хугацаанд тухайн бүс нутагт концесс эзэмшигчтэй өрсөлдөгч бий болгох төсөл хэрэгжүүлэхгүй байх;
- 7) энэ Гэрээний 3.8.1.3-т заасан нөхцөл үүссэний улмаас энэ Гэрээний 4.1.2.5-д заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч Гэрээний хугацааг сунгахгүйгээр шийдвэрлэсэн бол холбогдох нөхөн олговрыг энэ Гэрээний 7.8-д заасны дагуу тооцож олгоно.



4.2. Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

4.1.2. Энэ Гэрээний 3.10-т заасан онцгой эрхээс гадна концесс эзэмшигч дараахь эрх эдэлнэ:

- 1) концесс олгогчоос энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- 2) концессын гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл олж авах, дагалдах гэрээ хэлцлийг богино хугацаанд байгуулахад концесс олгогчоос дэмжлэг, туслалцаа авах;
- 3) энэ гэрээнд заасан нөхцөл, ажил үйлчилгээг өөрчлөх санал гаргах;
- 4) үйлдвэрлэлийн явцад техник технологийн схемд нэмэлт өөрчлөлт, оруулах зэрэг аливаа техникийн өөрчлөлтийн асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
- 5) үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээр Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийг эхний ээлжинд хангах ба бусад хэрэглэгчдэд эрчим хүчний хууль тогтоомжоор зөвшөөрсөн үнээр бусдад худалдах;
- 6) концессын зүйлд нийтийн зориулалттай дэд бүтэц, үйлчилгээг нэмэгдэл орлого олох зорилгоор ашиглах, энэ тохиолдолд үнэ тарифыг өөрөө тогтоох;
- 7) концессын зүйлийг хүлээлгэн өгөхдөө концессын зүйлд хамаарахаас бусад концессын явцад концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, олж авсан эд хөрөнгийг өөртөө үлдээх;
- 8) энэ гэрээгээр хориглосон, тусгайлан зөвшөөрсөнөөс бусад асуудлыг бие даан шийдвэрлэх, аж ахуйн үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй эрхлэх;
- 9) концессын гэрээний хугацаа дуусгавар болсоны дараа концесс олгогч зөвшөөрсөнөөр цахилгаан станц ашиглах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгөх, засвар үйлчилгээ хийх ажил үйлчилгээ хийж болно;

4.1.3. Концесс эзэмшигч энэ Гэрээний 3.11-д заасан үйл ажиллагаа эрхлэхгүй байхаас гадна дараах үүрэг хүлээнэ:

- 1) энэ Гэрээний дагуу хийж гүйцэтгэх ажлын тасралтгүй байдлыг хангах;
- 2) концессын зүйлийг энэ гэрээ болон ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт №1)-д заасан нөхцөлд нийцсэн хэмжээнд барьж байгуулан ашиглалтад оруулах ба ашиглах явцын засвар үйлчилгээ, шинэчлэлийг тогтоосон норм, нормативын хэмжээнд хийж, хүчин чадал, техникийн үзүүлэлт, тоног төхөөрөмж, үйлчилгээний чанарыг алдагдуулахгүй ашиглах;
- 3) энэ Гэрээний хэрэгжилттэй холбогдуулж концесс олгогчийн болон зохицуулах байгууллагын хууль тогтоомжийн дагуу шаардсан мэдээ, тайланг тавьсан шаардлага, хугацааны дотор хүргүүлж байх;
- 4) концессын гэрээ дуусгавар болоход энэ Гэрээний 4.1.3.2)-т заасан чанарын шаардлагыг хангасан цахилгаан станцын үндсэн болон туслах тоног төхөөрөмж, бусад дагалдах хэрэгслийг техник ашиглалтын бүх баримт бичиг, заавар, зааварчилгаа, ноу хауг-монгол хэлээр, нууцлалын кодын хамт концесс олгогч эсхүл түүнээс эрх олгосон этгээдэд хүлээлгэн өгөх;
- 5) барилга байгууламжийн зураг төсөл болон тоног төхөөрөмж бүрийн ашиглалтын зааврыг Монгол хэл дээр орчуулах, концесс олгогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өгөх;

- 6) төслийн гүйцэтгэгчийн хийсэн барилгын ажлын үе шатны ажлын нарийвчилсан төлөвлөгөө хуваарийг концесс олгогчид ирүүлэх, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж, энэ талаар концесс олгогчид тайлагнаж ажиллах;
- 7) барилга байгууламжийг энэ Гэрээний 3.4.1.7-д заасан хугацаанд ашиглалтад оруулах, туршилт хийх ажлыг бүрэн хариуцах, өөрийн болон төслийн гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт саатсан зэрэг шалтгаанаар төслийг хугацаанд нь оруулаагүйгээс үүсэн гарах хариуцлагыг бүрэн хүлээх;
- 8) хяналтын гэрээ (энэ Гэрээний хавсралт №9)-ний дагуу концесс олгогчийн томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтран ажиллах;
- 9) цахилгаан станцыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах чиглэлээр зохицуулах байгууллагууд болон орон нутгийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;
- 10) хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх тохиолдолд шалтгаан, үндэслэлийг тухай бүрт нь гаргаж концесс олгогчоор хянуулах ба концесс олгогчоор дамжуулан Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;
- 11) концессын зүйлийг шилжүүлэх үед концесс эзэмшигч бусдын өмнө хүлээсэн өр, төлбөр, бусдаас авах авлагаа бүрэн барагдуулсан байна;
- 12) концессын гэрээг хэрэгжүүлэх явцад шаардагдах энэ гэрээнд тусгайлан заагаагүй, ирээдүйд олж авах шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах, авсан нийт тусгай зөвшөөрлүүдийг концессын гэрээний хугацаанд, концессын зүйлийг шилжүүлэх хүртэл хүчинтэй байлгах;
- 13) эрчим хүчний барилга байгууламжийг барьж байгуулах, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, засвар үйлчилгээ, ашиглалт болон үйлдвэрлэлийн явцад эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, дүрэм журмыг даган мөрдөж ажиллах, тэдгээрт нийцүүлэн өөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг батлан дагаж мөрдөх;
- 14) нийтийн зориулалттай дэд бүтэц, үйлчилгээг нэмэгдэл орлого олох зорилгоор бусдад ашиглуулсан, түрээслэсэн тохиолдолд олсон орлогыг орлого, үр дүнгийн тайлан, тэнцэлдээ үнэн зөв тусгаж мэдүүлэх;
- 15) Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн бүртгэл тайлан, тооцоог хөтөлж, хуулиар тогтоосон хугацаанд зохих албан татвар төлж байх;
- 16) барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа эрх бүхий байгууллагаас баталсан "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм"-ийг удирдлага болгох бөгөөд түүнд заасны дагуу барилга байгууламжийг тогтоосон хугацаанд комисст чанарын сайн үнэлгээтэй хүлээлгэн өгөх;
- 17) барилга байгууламжийн засвар үйлчилгээг энэ Гэрээний хугацаанд бүрэн хариуцах;
- 18) концессын гэрээний хугацаанд барилга байгууламжийн засвар үйлчилгээг нэр хүнд бүхий, туршлагатай гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх, засвар үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр болон олж авсан хөрөнгөөр санхүүжүүлэх;
- 19) үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг эхний ээлжинд Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлэх;



- 20) концесс эзэмшигчийн буруугаас шалтгаалсан зөрчлийн улмаас барилга байгууламжийг барих явцын болон станцын үйл ажиллагаанд бүхэлд нь энэ Гэрээний 4.1.1.3 дахь заалтын дагуу хөндлөнгийн шинжээч томилох, 4.1.1.8 дахь заалтын дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тохиолдолд тэдгээрийн ажлын хөлс, бусад зардлыг концесс эзэмшигч хариуцна.

ТАВ. КОНЦЕСС ХЭРЭГЖИХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДАЛ

5.1. Газар ашиглуулах

- 5.1.1. Концессын зүйлийг барьж байгуулах газрыг цахилгаан станц барих нутаг дэвсгэрийн орон нутгийн газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллага гэрээний үндсэн дээр цахилгаан станцын ашиглалтын хугацаагаар концесс эзэмшигчид олгоно.
- 5.1.2. Концесс эзэмшигч олгосон газрыг зөвхөн цахилгаан станц барьж байгуулахад зориулж, газар ашиглах гэрээнд заасан нөхцөлөөр ашиглана.
- 5.1.3. Газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт №5)-ний хугацаа, олгох газрын хэмжээ, нөхцөлийг Газрын тухай хуулийн дагуу тодорхойлно.
- 5.1.4. Газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт №5)-ний дагуу концесс эзэмшигчийн ашиглах газрыг энэ Гэрээний хугацаанд улсын тусгай хэрэгцээнд буюу бусад олон нийтийн хэрэгцээнд ашиглах зорилгоор төр хурааж авахгүй.
- 5.1.5. Концесс эзэмшигч нь газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт №5)-ний дагуу газрыг ашиглахдаа байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй нөхцөлөөр ашиглах үүрэг хүлээх ба газар ашиглалтын үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хуульд заасан шаардлагыг хангаж, ашиглана.
- 5.1.6. Концесс эзэмшигч нь газар ашигласны төлбөрийг Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хуульд заасны дагуу төлнө.

5.2. Нүүрсний хангалт

- 5.2.1. Цахилгаан станцын түлшний гол эх үүсвэрийн нөөц нь Могойн голын нүүрсний уурхай байна.
- 5.2.2. Цахилгаан станцад нийлүүлэх нүүрсний хэмжээ, чанар, үнийг тогтвортой байлгах асуудлыг энэ гэрээний ерөнхий зүйлийн 1.3.1-т дурьдсан Могойн голын нүүрсний уурхайтай байгуулсан "Нүүрс бэлтгэн нийлүүлж, худалдах, худалдан авах гэрээ" (энэ Гэрээний хавсралт №4)-гээр зохицуулна.
- 5.2.3. Нүүрсний уурхайн хэвийн үйл ажиллагааг хангахад уурхайн удирдага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай талууд бүхий л чиглэлээр харилцан ойлголцож, хамтран ажиллана. Цахилгаан станцын ойр орчимд шинээр нүүрсний нөөц тогтоогдох, түүнийг ашиглах тохиолдолд концесс эзэмшигч нүүрс худалдан авах гэрээг хийх замаар нүүрсний нөөц хангалтыг тогтвортой байлгах бүхий л арга хэмжээг авч болно.
- 5.2.4. ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт №1)-д дурдсан Могойн голын нүүрсний уурхайн үйл ажиллагааг жигдрүүлэх, уурхайг өргөтгөх, хэвийн үйл ажиллагааг хангах тал дээр концесс олгогч, орон нутгийн эрх бүхий байгууллага, Могойн голын нүүрсний уурхайн удирдлага болон концесс эзэмшигч хамтран ажиллаж, цахилгаан станцыг нүүрсээр тогтвортой хангах ажлыг дэмжин ажиллана.



5.3. Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах ба үнэ тариф

- 5.3.1. Цахилгаан станцыг барьж байгуулж ашиглалтад оруулах явцад станцад шаардлагатай цахилгаан эрчим хүчийг энэ Гэрээний ерөнхий зүйлийн 1.3.3-т дурьдсан “АУЭХС” ТӨХК-тай байгуулсан “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” (энэ Гэрээний хавсралт №6)-гээр зохицуулна. Гэрээг хууль тогтоомжид заасны дагуу тухай бүр шинэчлэн мөрдөж ажиллана.
- 5.3.2. Цахилгаан станц ашиглалтад орсноос хойш үйлвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг Алтай-Улиастайн эрчим хүчний нэгдсэн сүлжээ, цаашид Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэх харилцааг эрх бүхий байгууллагуудтай тухай бүр гэрээ байгуулж зохицуулна.
- 5.3.3. Худалдан авах болон нийлүүлэх цахилгаан эрчим хүчний нэгж цахилгааны чадлын болон энергийн тарифыг Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн дагуу эрчим хүчний үнэ тариф, зохицуулалт хариуцсан зохицуулах байгууллага тогтоож мөрдүүлнэ.
- 5.3.4. Цахилгаан станц ашиглалтад орж, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлэлт хийж эхэлсэнээр нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг стандарчлал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталгаажуулсан хэмжих хэрэгслийг ашиглан тооцоо хийнэ.
- 5.3.5. Үйлдвэрлэсэн, нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг хэмжих, тоолох, хяналтын болон хэмжилтийн тоолуур ашиглах, өмчлөхтэй холбоотой харилцааг талууд холбогдох этгээдтэй гэрээ байгуулах замаар зохицуулна.

5.4. Даатгал

- 5.4.1. Концесс эзэмшигч концессын гэрээний хэрэгжилтийн үе шат бүрт концессын зүйлийг Концессын тухай хуулийн 26.5-д заасны дагуу гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.
- 5.4.2. Гэрээний 5.4.1-д заасан даатгалын төрөлд даатгуулах үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан бүх зардал, эрсдлийг концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцна.

5.5. Техникийн нөхцөл, үзүүлэлт

- 5.5.1. Концессын зүйлийг барьж байгуулах барилгын ажил эхлэхээс өмнө концесс эзэмшигч нь уг барилга байгууламжийг дулаан, уур, цэвэр, бохир ус, холбоожуулалт, цахилгаан, радио, дохиоллын эх үүсвэрт холбох эрх олгосон шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргуулсан байна.
- 5.5.2. Барилга байгууламжид тавих техникийн улсын хяналтыг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч хэрэгжүүлнэ.
- 5.5.3. Цахилгаан станцыг ашиглалтад оруулах, энэ Гэрээнд заасан нөхцлөөр хүлээлгэн өгөх үед цахилгаан станцын үндсэн болон туслах тоноглол, дагалдах хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийн байдал, техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны бэлэн байдлыг шалган баталгаажуулах, техникийн дүгнэлт, шалгуур нөхцлийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно.

5.6. Санхүү, хөрөнгө оруулалт

- 5.6.1. Концесс эзэмшигч болон түүний холбогдох этгээд нь Концессын тухай Монгол улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх хэсэг, энэ Гэрээний



- 3.4.1.3)-т заасан шаардлагын дагуу санхүүгийн чадавхитай болохоо нотлох үүрэг хүлээнэ.
- 5.6.2. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ энэ Гэрээний 3.4.1.3)-т заасан хэмжээнд байна. Энэ хэмжээ тогтвортой бөгөөд эцсийн байна. Зөвхөн Засгийн газрын шийдвэрээр өөрчилж болно.
- 5.6.3. Хөрөнгө оруулалтын хэмжээ, хуваарийг “Төслийн санхүүжилтийн гэрээ”-нд зааснаар хэрэгжүүлнэ.
- 5.6.4. Цахилгаан станцын өөрийн өртөг, төслийн санхүүжилт, орлого, үр ашгийн тооцоог ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт №1), барилгын зураг төсөлд заасан төсвийг удирдлага болгож тооцно. Концесс эзэмшигчийн санхүүгийн тайланд тусгагдсан концессын зүйлийн өртөгийг тооцохдоо орлого ашгийн дүнг Төв банкнаас зарласан тухайн үеийн валютын ханшаар, жил бүр хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийн дагуу тооцон талууд тооцоог нийлж, дараа жилийн эхний улиралд багтаан үлдэгдэл өртөгийг тодорхойлж, акт үйлдэж байна.

ЗУРГАА. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА

- 6.1. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон талуудын хооронд болон гуравдагч этгээдэд дараахи мэдэгдэл, баталгааг гаргаж байна. Үүнд:
- 6.1.1. Концесс эзэмшигч нь Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хуулийн этгээдийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгэгдсэн, хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдэг болохыг;
- 6.1.2. Энэ төслийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компани нь энэ Гэрээний хугацаанд өөр бусад төсөл болон бизнесийн үйл ажиллагаа эрхлэхгүйг;
- 6.1.3. Холбогдох хууль тогтоомж, үүсгэн байгуулах баримт бичигт заасны дагуу концесс эзэмшигч энэ гэрээг байгуулах, түүнд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх болохыг баталгаажуулсан шийдвэрийг компаний эрх барих дээд удирдлагаас хүлээн авсаны үндсэн дээр энэ гэрээ байгуулагдсан болохыг;
- 6.1.4. Концесс эзэмшигч нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн найдвартай эх үүсвэртэй, санхүүгийн чадвартай болохыг;
- 6.1.5. Энэ гэрээгээр хүлээсэн үүрэг нь хууль ёсны, заавал биелэгдэх шинжтэй бөгөөд энэ Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаварыг талууд гэрээнд заасны дагуу бүрэн хүлээхийг;
- 6.1.6. Талууд энэ гэрээнд хамаарах Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох бүх хууль тогтоомжийг биелүүлэх үүрэгтэй болохыг;
- 6.1.7. Концесс эзэмшигч энэ гэрээг байгуулж буй нь түүний гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл болон концесс эзэмшигчийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг хөндсөн гэрээ, хэлцэл, санамж бичиг, тушаал, захирамжийг зөрчөөгүй, тэдгээртэй харшлаагүй болохыг;
- 6.1.8. Төслийн хэрэгжилтэд ноцтой нөлөөлөхүйц эсвэл сөрөг үр дагавар үүсгэх маргаан хуулийн байгууллагад шалгагдаж, хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаагүй, гуравдагч этгээд концесс эзэмшигчийн эсрэг шүүхэд аливаа нэхэмжлэл гаргаагүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй;
- 6.1.9. Концессын гэрээний хугацаа дуусмагц концесс эзэмшигч нь гэрээнд заасны дагуу төсөл болон концессын зүйлтэй холбоотой бүх эрхийг концесс олгогчид бүрэн шилжүүлэхийг;
- 6.1.10. Концесс эзэмшигчээс концесс олгогч болон төрийн байгууллагад өгөх мэдээлэл нь үнэн зөв бөгөөд мэдээллийг орхигдуулаагүй болохыг;



6.1.11. Концесс олгогч концесс олгох бүрэн эрхтэй болохыг:

ДОЛОО. КОНЦЕССЫН ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

7.1. Концессын гэрээ дуусгавар болох

7.1.1. Дор дурьдсан үндэслэлээр концессын гэрээ дуусгавар болно:

- 1) талууд харилцан тохирсоноор;
- 2) концессын гэрээний хугацаа дууссан, гэрээг сунгаагүй;
- 3) концесс эзэмшигч татан буугдсан, дампуурсан;
- 4) концессын гэрээг энэ гэрээнд заасан үндэслэлээр цуцалсан.

7.1.2. Концессын гэрээ дуусгавар болсоноор концессын зүйлийг эзэмшиж ашиглах концесс эзэмшигчийн эрх дуусгавар болж энэ Гэрээний 7.7-д заасны дагуу концесс эзэмшигч концессын зүйлийг концесс олгогчид хүлээлгэн өгнө.

7.1.3. Концесс эзэмшигч татан буугдсан, дампуурсан, эсхүл энэ Гэрээний 7.3.1-т заасан үндэслэлээр концессын гэрээг цуцалсан тохиолдолд концесс эзэмшигчийн эрх, үүргийг концесс олгогч өөртөө түр шилжүүлэн авах буюу дараагийн концесс эзэмшигчид энэ Гэрээний 7.7-д заасны дагуу хүлээлгэж өгнө.

7.1.4. Концесс эзэмшигч татан буугдсан, дампуурсан бол энэ талаар шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийг үндэслэн концесс олгогч концесс эзэмшигчийн эрх, үүргийг шилжүүлэн авна.

7.2. Концессын гэрээг цуцлах

7.2.1. Дор дурдсан үндэслэлээр концессын гэрээг цуцална:

- 1) талуудын нэг талын санаачилгаар;
- 2) энэ Гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөн;
- 3) энэ Гэрээний 7.5.1.1, 7.5.1.3-т дурьдсан давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээ цуцлах нөхцөл байдал бий болсон;

7.3. Концессын гэрээг нэг талын санаачилгаар цуцлах

7.3.1. Дараахь тохиолдолд концесс олгогчийн санаачилгаар концессын гэрээг цуцална:

- 1) үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн;
- 2) концесс олгогчийн зөвшөөрөлгүйгээр концесс эзэмшигч энэ Гэрээний 3.11-д хориглосон үйл ажиллагаа явуулсан;
- 3) концесс эзэмшигч татан буугдсан буюу дампуурсан;
- 4) концесс эзэмшигч Монгол улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөнийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 5) концесс эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан энэ Гэрээний 3.3-т заасан гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хэрэгжихгүй болсон, 3.4.1.4-д заасан нөхцөл хэрэгжих нь тодорхойгүй, 3.4.1.5-д заасан гэрээг хугацаанд нь байгуулаагүй.

7.3.2. Дор дурдсан үндэслэлээр концесс эзэмшигчийн санаачилгаар концессын гэрээг цуцална:



- 1) энэ Гэрээний 10.2.1-д заасан хууль тогтоомж өөрчлөгдсөнөөр гэрээг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- 2) концесс эзэмшигчийн буруугаас энэ Гэрээний 3.4.1.5-д заасан тусгай зөвшөөрөл олгогдоогүй, эсхүл олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- 3) энэ Гэрээний 7.5-д заасан нөхцөл байдал бий болсон.

7.4. Гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөний улмаас гэрээ цуцлах

7.4.1. Дор дурдсан нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөн гэж үзэж, талуудын санаачилгаар концессын гэрээг цуцална.

- 1) концесс олгогч хууль тогтоомж, энэ гэрээнд заагдаагүй үндэслэлээр энэ гэрээг цуцлах шийдвэр гаргасан;
- 2) концесс эзэмшигч энэ Гэрээний 3.4.1.7)-д заасан хугацаанд барилга угсралтын ажлыг гүйцэтгэж чадахгүй болсон;
- 3) хөрөнгө оруулагч энэ гэрээнд заасан хэмжээний хөрөнгө оруулалтыг оруулах боломжгүй болсон;
- 4) концессын зориулалттай олгосон газар, тусгай зөвшөөрлийг бусдад зарсан;
- 5) гэрээний үүргээс зайлсхийх зорилгоор санаатайгаар дампуурсан, татан буулгасан;
- 6) энэ гэрээгээр хориглосон аливаа үйл ажиллагаа явуулах, концессын зүйлийг энэ гэрээгээр олгосоноос өөр зорилгоор эзэмшиж, ашигласан.

7.5. Давагдашгүй хүчин зүйл бий болсоны улмаас гэрээ цуцлах

7.5.1. Дор дурдсан улс төрийн ба улс төрийн бус, бусад нөхцөл байдал бий болсоныг давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болсонд тооцож, талууд концессын гэрээг цуцална.

- 1) энэ Гэрээний 10.3.1.1-д заасан давагдашгүй хүчин зүйлийн улмаас концессын зүйл устаж алга болсон;
- 2) давагдашгүй хүчин зүйлийн улмаас концессын зүйлд учирсан хохирлыг барагдуулахад концессын зүйлийн орлого хүрэлцэхгүй, түүнийг сэргээн засварлахад шаардлагатай хөрөнгийг талууд гаргах боломжгүй болсон;
- 3) энэ Гэрээний 10.3.2.2)-г заасан концессын зүйлийг төр дайчлан хураан авсан;
- 4) энэ Гэрээний 10.3.2.1)-д заасан улс төрийн хүчин зүйлийн улмаас хууль тогтоомж өөрчлөгдөж, хууль бусаар тусгай зөвшөөрөл цуцлагдсан, олгохоос татгалзсан нь энэ гэрээг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болгосон, эсхүл гэрээний анхны нөхцөл бүхэлдээ өөрчлөгдөх байдалд хүргэж, хэрэгжүүлэх боломжгүй болгосон;
- 5) энэ Гэрээний 10.3.3.1)-д заасан дайн байлдааны байдал үүссэн улс төрийн, төрийн бус хүчин зүйлийн улмаас энэхүү нөхцөл байдал удаан хугацаанд үргэлжлэх нь тодорхой болсон.

7.6. Гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх

7.6.1. Гэрээг цуцлах тухай санал, мэдэгдлээ талууд бичгээр хүргүүлнэ.



- 7.6.2. Гэрээ цуцлах тухай урьдчилсан мэдэгдэл өгснөөс хойш 1 (нэг) сарын хугацаанд талууд нөхцөл байдлыг судалж, гэрээ цуцалсанаас үүдэн гарах үйл явдлын үр дагаврыг багасгах зорилгоор зөвлөлдөж, эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлээр хамтран ажиллах үүрэг хүлээнэ.
- 7.6.3. Концесс эзэмшигчийн үүрэг ноцтой зөрчигдсөнөөс концесс олгогч түүнд энэ гэрээг цуцлах урьдчилсан мэдэгдэл ирүүлсэн бол концесс эзэмшигч нь энэ тухай хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч нартаа урьдчилан мэдээлнэ.
- 7.6.4. Мэдэгдэлд заасан хугацаанд концесс эзэмшигч ноцтой зөрчлийг арилгах талаар санаачилга гаргахгүй, шийдвэртэй арга хэмжээ авахгүй, үүссэн нөхцөл байдлыг сайжруулах хүсэлгүй, өөрийн хүчээр ноцтой зөрчил үүсгэж байгаа нөхцөл байдлыг арилгаж чадахааргүй бол концесс олгогч нь энэ талаар хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч нарт бичгээр мэдэгдэж, нэмэлт хугацаа өгөх, шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч нартай шууд харьцаж, өөрийн саналыг хүргүүлж болно.
- 7.6.5. Талууд гэрээнд өөрөөр тохиролцоогүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал өөрчлөгдөөгүй, арилаагүй бол, эсхүл ноцтой зөрчигдсэн үйлдлийг арилгах үүрэг хэрэгжээгүй бол гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл өгсөнөөс хойш 30 хоногийн дотор нөгөө тал хариу санал ирүүлсэнээр, эсхүл хариу ирүүлэх Иргэний хуульд заасан хугацаа өнгөрсөн өдрөөс энэ гэрээг цуцлагдсанд тооцно.

7.7. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх

- 7.7.1. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх талаар концесс олгогч болон эрх бүхий этгээд шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийг үндэслэн концесс олгогч концессын зүйлийг хүлээлцэх комиссыг нэн даруй томило.
- 7.7.2. Шийдвэрээр концессын зүйлийг хүлээлгэн өгөх эцсийн хугацаа, комиссын бүрэлдэхүүн, комиссын ажлын удирдамжийг батална.
- 7.7.3. Энэ Гэрээний 7.7.4-т зааснаас бусад үндэслэлээр гэрээ цуцлагдаж, дуусгавар болсон тохиолдолд концессын зүйл болон концесс эзэмшигчийн эрх, үүргийг концесс олгогч болон түүнээс эрх олгосон этгээдэд үнэ төлбөргүйгээр шууд шилжүүлж хүлээлгэн өгнө. Энэ тохиолдолд концесс эзэмшигч концессын зүйлийг комиссоос тогтоосон хугацаанд чөлөөлнө.
- 7.7.4. Энэ Гэрээний 7.3.1, 7.4.1, 7.5.1-д заасан үндэслэлээр гэрээ цуцлагдаж, дуусгавар болж байгаа тохиолдолд концессын зүйл болон концесс эзэмшигчийн эрх, үүргийг концесс олгогч, түүнээс эрх олгосон этгээдэд шилжүүлж, хүлээлгэн өгөхөд концессын зүйлийг энэ Гэрээний 7.8-д заасан дагуу үнэлж, нөхөн олговор тооцож өгнө. Төлбөр тооцоо дуусмагц концесс эзэмшигч комиссоос тогтоосон хугацаанд концессын зүйлийг чөлөөлнө.
- 7.7.5. Комисс концессын зүйлийг хүлээлцэхдээ дараах зарчмыг баримтална:
- 1) төрд буюу концесс олгогч, орон нутгийн өмч, түүнчлэн концесс эзэмшигчийн өмчлөлд үлдэх эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж тодорхойлно;
 - 2) татан буугдсан буюу дампуурсан тохиолдолд концесс эзэмшигчийг дахин хөрөнгөжүүлэх, өөрчлөн байгуулах, эрх үүргийг нь шилжүүлж болох арга хэмжээний төлөвлөгөөг хийж, шийдвэрлүүлнэ;
 - 3) концессын зүйлийн чанар байдалд мэргэжлийн комисс дүгнэлт гаргаж, баталгаажуулна;
 - 4) концессын зүйлийг хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулна.
- 7.7.6. Концесс эзэмшигч нь энэ Гэрээний хугацаа дуусахаас 1 /таван/ жилийн өмнө концессын зүйлд их засвар хийсэн байна.



7.7.7. Концесс эзэмшигч энэ Гэрээний 7.7.6-д заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд концесс олгогч нь нэг удаа бичгээр үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд энэ гэрээ цуцлагдах үндэслэл болох бөгөөд концесс эзэмшигч их засварын шаардагдах хөрөнгийг концесс олгогчийн дансанд шилжүүлнэ.

7.8. Концессын зүйлийг үнэлэх, нөхөн олговрын хэмжээ тооцох

7.8.1. Энэ Гэрээний 7.3.1, 7.5.1-д дурьдсан давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээ цуцлагдсан нөхцөлд концесс олгогч дор дурьдсан томъёоллын дагуу концессын зүйлийг үнэлж, нөхөн олговор төлнө:

$$KZY = K3\Theta - ДНТ + ИОА$$

KZY = Концессын зүйлийн үнэ

$K3\Theta$ = Концесс эзэмшигчийн санхүүгийн тайланд тусгагдсан концессын зүйлийн (элэгдэл тооцсон) үлдэгдэл өртөг болон Концесс эзэмшигчээс санхүүжүүлэгчид төлөх өр төлбөрийн аль багаар тооцож гаргасан концессын зүйлийн өртөг

$ДНТ$ = Концесс эзэмшигчид төлөгдсөн даатгалын нөхөн төлбөр

$ИОА$ = Ирээдүйд олохоор тооцоологдсон ашиг

7.8.2. Энэ Гэрээний 7.4.1.2)-7.4.1.6)-д заасан гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөний улмаас энэ гэрээ цуцлагдсан тохиолдолд концесс олгогч нь дор дурьдсан томъёоллын дагуу концессын зүйлийн үнэлгээг тооцож, нөхөн төлбөр олгоно:

$$KZY = K3\Theta - (XHT + TT)$$

$K3\Theta$ = Концесс эзэмшигчийн санхүүгийн тайланд тусгагдсан концессын зүйлийн (элэгдэл тооцсон) үлдэгдэл өртөг болон концесс эзэмшигчээс хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч нарт төлөх өрийн дүнгийн аль багаар тооцож гаргасан концессын зүйлийн өртөг;

XHT = Концесс эзэмшигчээс концесс олгогчид төлөх аливаа хохирлын нөхөн төлбөр (энэ Гэрээний 8 дугаар зүйлд заасны дагуу концесс эзэмшигчийн төлөх хохирол):

TT = Концесс эзэмшигчээс концесс олгогчид энэ Гэрээний 8 дугаар зүйлд заасны дагуу төлөх алданги, торгууль, анз.

7.8.3. Энэ Гэрээний 7.4.1.1)-д заасан концесс олгогчийн гаргасан ноцтой зөрчил, 7.3.1.1-д заасан шийдвэр гарсны улмаас энэ Гэрээ цуцлагдсан тохиолдолд концесс олгогч нь дор дурьдсан томъёоллын дагуу тооцсон үнэлгээгээр нөхөн төлбөр олгоно:

$$KZY = K3\Theta + YXOBBO$$

КЗӨ = Концесс эзэмшигчийн санхүүгийн тайланд тусгагдсан концессын зүйлийн (элэгдэл тооцсон) үнэ болон концесс эзэмшигчээс хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгчид төлөх өрийн дүнгийн аль ихээр тооцож гаргасан концессын зүйлийн өртөг;

ҮХОББ= үлдсэн хугацаанд олох байсан боломжит орлого

- 7.8.4. Гэрээ цуцлагдсанаар концесс олгогч концессын зүйлийг нөхөн төлбөртэйгээр өөртөө болон эрх олгосон этгээддээ шилжүүлэн авах нөхцөлд үүнтэй холбогдон гарах аливаа зардал, тэмдэгтийн хураамж, нотариатын төлбөр, холбогдох татвар болон бусад төлбөр, хураамжийг концесс олгогч хариуцна.
- 7.8.5. Гэрээ цуцлагдсанаар концесс олгогч концессын зүйлийг нөхөн төлбөргүйгээр өөртөө болон эрх олгосон этгээддээ шилжүүлэн авах нөхцөлд үүнтэй холбогдон гарах аливаа зардал, тэмдэгтийн хураамж, нотариатын төлбөр, холбогдох татвар болон бусад төлбөр, хураамжийг концесс эзэмшигч хариуцна.
- 7.8.6. Гэрээний хугацаа дуусгавар болсноор концесс эзэмшигч нь концессын зүйлийг концесс олгогчийн эзэмшил, өмчлөлд аливаа саад учруулахгүйгээр шилжүүлж, хүлээлгэн өгнө.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Энэ Гэрээний зүйл, заалтыг дор дурдсанаар зөрчсөн нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй гэж талууд үзсэн тохиолдолд буруутай тал дараахь хариуцлага хүлээлгэнэ:
- 8.1.1. энэ гэрээнд заасан аливаа үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа шууд буюу шууд бус аливаа хохирол учруулсан бол зөрчил гаргасан тал хохирогч талдаа учруулсан бодит хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Хохирлын хэмжээг эс зөвшөөрсөн тохиолдолд хохирол нэхэгч тал хуулийн байгууллагад хандаж, хохирлын хэмжээг тогтоолгож болно.
- 8.1.2. Гэрээний дор дурдсан үүрэг зөрчигдсөн тохиолдолд дараах анз хүлээнэ:
- 1) Энэ Гэрээний 3.3.1-д заасан гэрээг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөлийг цаг хугацаанд нь гүйцэтгэж чадаагүйгээс энэ гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хуанлийн 120 хоногийн дотор барилгын ажил эхлээгүй бол буруутай этгээдийг гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хүртэл хувиар торгоно.
 - 2) Барилга байгууламжийг угсрах явцад чанарын шаардлага хангаагүй барилгын материал тоног төхөөрөмжийг нийлүүлэх, ашиглах, эсхүл энэ хууль тогтоомж, энэ гэрээнд заасан шалгуур шаардлагад нийцэхгүй үндсэн болон туслах тоноглол, бусад хэрэгслийг нийлүүлж, угсрах, ашиглах тохиолдолд тухайн тоног төхөөрөмж, тоноглол, хэрэгслийн үнийн дүнгийн 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.
 - 3) Цахилгаан станц, дагалдах байгууламжийн хамт энэ Гэрээний 3.4.1.7-д заасан хугацаанд ашиглалтад бүрэн оруулаагүй тохиолдолд хугацаг хэтрүүлсэн хоног тутамд энэ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хүртэл хувиар тооцож, алданги ногдуулна.



- 4) Үйлдвэрлэсэн цахилгааныг эхний ээлжид Алтай-Улиастайн эрчим хүчний сүлжээнд нийлүүлээгүй тохиолдолд үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг худалдан борлуулсаны орлогын 10 хүртэл хувиар тооцож, торгууль ногдуулна.
- 8.1.3. Хохирлын хэмжээг талууд эс зөвшөөрч байгаа тохиолдолд Монгол улсын Иргэний хуульд заасны дагуу шүүхээр тогтоолгож болно. Хохирол төлсөн нь энэ гэрээг бүхэлд нь хүчингүй болгох, цуцлах үндэслэл болохгүй.
- 8.1.4. Концесс эзэмшигч, түүний ажилтан, албан тушаалтан, төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл төслийн гүйцэтгэгч, гэрээт гүйцэтгэгчийн ажилтнуудын хайхрамжгүй, санаатай болон санамсаргүй, аливаа үйлдэл, эс үйлдлээс шалтгаалж концесс олгогч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг концесс эзэмшигч хариуцан арилгуулах үүрэгтэй.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Энэ гэрээнээс үүссэн болон түүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд эвийн журмаар, хэлэлцээр хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 9.2. Маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Тэнхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрын “Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм”-ын дагуу заавал биелүүлэх арбитрийн зарчмаар шийдвэрлэгдэнэ. Арбитрын ажиллагааг дараахь зарчмаар явуулна:
- 9.2.1. арбитрчийн тоо 3 /гурав/ байх;
- 9.2.2. арбитрчдийг “Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм”-д заасан журмын дагуу томилох;
- 9.2.3. арбитрын ажиллагааг монгол хэл дээр явуулах;
- 9.2.4. арбитрын ажиллагааг Монгол улсын Арбитрын хууль, Монгол улсын Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн дэргэдэх Монголын Үндэсний Арбитрын “Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм”-ын дагуу явуулна;
- 9.2.5. арбитрын ажиллагааг Монгол улсын Улаанбаатар хотод явуулна.
- 9.3. Арбитрын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд уг шийдвэрийг талууд заавал биелүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛС

10.1. Хууль хэрэглэх

- 10.1.1. Гэрээнээс үүдэн гарах аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол улсын хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны тайлбарыг удирдлага болгоно. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

10.2. Хууль тогтоомж өөрчлөгдөх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээ

- 10.2.1. Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орж мөрдөгдөж эхэлсэн Монгол улсын эрчим хүчний салбарын бодлого, энэ Гэрээний хөрөнгө оруулалт, санхүүжилтэд нөлөөлөх болон энэ гэрээнд оролцогчдын бүрэн эрх, ашиг, сонирхлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хөндсөн, өөрчилсөн, нөлөөлсөн Монгол Улсын

аливаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр гарсаныг нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.2.2. Энэ гэрээ байгуулсан үед мөрдөгдөж, үйлчилж байсан Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын олон улсын гэрээ өөрчлөгдсөнөөр энэ гэрээ хэрэгжих эрх зүйн орчин өөрчлөгдөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ талаар мэдсэн тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана:

- 1) өөрчлөлт орсон хууль тогтоомжийн эх сурвалж, орсон өөрчлөлтийн агуулга;
- 2) өөрчлөлт нь талуудын ашиг сонирхол, төслийн цаашдын хэрэгжилтэд хэрхэн яаж нөлөөлөх, нөлөөлж эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 3) өөрчлөлттэй холбогдон авах арга хэмжээний санал.

10.2.3. Мэдэгдлийг хүлээн авсан тал хүлээн авснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор өөрийн саналаа нөгөө талдаа хүргүүлж, хэлэлцэн тохиролцох үүрэгтэй.

10.2.4. Энэ Гэрээний 10.2.4-т заасан хугацаанд хууль тогтоомж өөрчлөгдсөнөөс үүдэн гэрээнд зайлшгүй оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар тохиролцож чадаагүй бол энэ Гэрээний 3.9.6-д зааснаар гэрээ цуцлах санал гаргах эрх үүснэ.

10.3. Давагдашгүй хүчин зүйл

10.3.1. Дараахи үйл явдал, нөхцөл байдал үүссэнийг давагдашгүй хүчин зүйл бий болсонд тооцож, улс төрийн бус хүчин зүйлд хамааруулан ойлгоно:

- 1) үер, газар хөдлөлт, хөрсний гулсалт, дэлбэрэлт, гал түймэр, хүчтэй шуурга, аадар бороо, эрс хүйтрэлт, цаг агаарын гэнэтийн ноцтой үзэгдэл зэрэг байгалийн гамшигт нөхцөл байдал бий болох;
- 2) тахал, халдварт өвчин гарах буюу хорио цээр тогтоох;

10.3.2. Дараахь үйл явдал, нөхцөл байдал үүссэнийг давагдашгүй хүчин зүйл бий болсонд тооцож, улс төрийн хүчин зүйлд хамааруулан ойлгоно:

- 1) станцын үйл ажиллагаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц хууль тогтоомжийн өөрчлөлтийг хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага батлаж, мөрдүүлэх;
- 2) эд хөрөнгө нийгэмчлэх, хураах, дайчлан авах;
- 3) холбогдох тусгай зөвшөөрлүүдийг хуульд зааснаас бусад үндэслэлээр цуцлах, шинээр олгох болон шинэчлэхээс хууль зүйн үндэслэлгүйгээр татгалзах;
- 4) үндэсний эрх ашиг, аюулгүй байдал болон үндэсний онц байдлын улмаас концесс олгогч гэрээг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө цуцлах;

10.3.3. Дараах үйл явдал, нөхцөл байдал үүссэнийг давагдашгүй хүчин зүйл бий болсонд тооцож, бусад хүчин зүйлд хамааруулан ойлгоно:

- 1) дайн байлдаан, түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гадны халдлага, бүслэлт, худалдааны хориг, хувьсгал, засгийн эрхийн төлөөх хүч түрэмгийлсэн бослого, хуйвалдаан, үймээн, терроризм, улс төрийн зорилго бүхий хорлон сүйтгэх болон барьцаалах ажиллагаа эхэлсэн;
- 2) улс даяар өрнөсөн эсхүл салбар хамарсан ажил хаялт, бослого;



3) станцын үйл ажиллагааг эсэргүүцсэн иргэний хөдөлгөөн, бослого, улс төрийн жагсаал, цуглаан.

10.4. Давагдашгүй хүчин зүйл арилсаны үр дүнд авах арга хэмжээ

- 10.4.1. Энэ Гэрээний 10.3-т дурьдсан давагдашгүй хүчин зүйлийн энэ Гэрээний 7.5-д зааснаас бусад нөхцөл байдал арилсанаар давагдашгүй хүчин зүйл арилсанд тооцож, хохирогч тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон байсан эрх, үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 10.4.2. Давагдашгүй хүчин зүйлийг бий болгож байсан нөхцөл арилсан боловч хохирогч тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон байсан эрх, үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй бол уг эрх, үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Талууд харилцан тохиролцож, шаардлагатай тохиолдолд энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ;
- 10.4.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэ гэрээнд заасан эрх, үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар талууд харилцан тохиролцож, энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ Гэрээний 7.3.1.4), 7.3.2.3)-т зааснаар гэрээг цуцлах үндэслэл болно;
- 10.4.4. Давагдашгүй хүчин зүйл бий болохоос өмнө гүйцэтгэх ёстой байсан мөнгөн төлбөрийн үүргийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас гүйцэтгэж чадаагүй нь хохирогч талыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 10.4.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хохирогч тал гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон нь эрх бүхий байгууллага тогтоосон тохиолдолд учирсан хохирлыг даатгалын нөхөн төлбөрийг ашиглан барагдуулах арга хэмжээ авна.
- 10.4.6. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгоор байгуулсан даатгалын нөхөн төлбөр уг хохирлыг барагдуулахад бүрэн хүрэлцэхгүй тохиолдолд үүнээс үүдэн гарсан хохирлыг талууд адил тэгш хүлээж, хариуцна. Энэ тохиолдолд хохирлын хэмжээг тодорхойлох хөндлөнгийн шинжээч баг ажиллуулна.
- 10.4.7. Давагдашгүй хүчин зүйл бий болсоны улмаас гүйцэтгэх ёстой байсан мөнгөн төлбөрийн үүргийг гүйцэтгэж чадаагүй, энэ Гэрээний 10.4.6-д заасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр даатгалын нөхөн төлбөр уг хохирлыг барагдуулахад бүрэн хүрэлцэхгүй тохиолдолд нь хохирогч талыг хариуцлагаас чөлөөлөх тухай асуудлыг концесс олгогч шийдвэрлэнэ.
- 10.4.8. Хохирогч тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөх цар хүрээнээс илүү хэмжээгээр, эсвэл үргэлжлэх хугацаанаас урт хугацаагаар энэ гэрээгээр хүлээсэн үүргийг хугацаанд нь гүйцэтгэхээс татгалзах, түтгэлзүүлэх эрхгүй.

10.5. Нууц хадгалах

- 10.5.1. Талууд энэ Гэрээний дагуу хоорондоо солилцож байгаа төсөлтэй холбоотой, нууцлалын шинжтэй бүх гэрээ хэлэлцээр, баримт бичиг, мэдээллийн нууцлалыг чанд хадгална.
- 10.5.2. Мэдээллийн нууцад зураг төсөл, барилга байгууламжийн ажил, даатгал, үйл ажиллагаа, засвар, удирдлага, төслийн санхүүжилттэй холбоотой бүх баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэл хамрагдана. Гэрээний үндсэн дээр олж авсан аль нэг талын үүрэгтэй холбогдсон аливаа баримт бичиг болон мэдээлэл /техникийн эсхүл арилжааны эсэхээс үл хамааран)-



ийг гэрээний дагуу үүрэг гүйцэтгэх, эрх хэрэгжүүлэхээс бусад зорилгоор ашиглахгүй. Гэрээний нууц алдагдсанаас аль нэг талд хохирол учирвал нөгөө тал учирсан хохирлыг Монгол улсын Иргэний хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй.

10.6. Мэдэгдэл хүргүүлэх

10.6.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэ Гэрээний дагуу хүргүүлэх шаардлагатай мэдэгдэл, санал, албан бичиг баримтыг биет төлөөлөгчөөрөө дамжуулан биечлэн хүргүүлэх буюу дор дурьдсан хаягаар баталгаат буухиа шуудан, факс болон электрон шуудан, факсаар хүргүүлнэ:

Концесс олгогчид хүргүүлэх бол:

Концесс эзэмшигчид хүргүүлэх бол:

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

“ШИНЭ АЗИА ГРУПП” ХХК

Засгийн газрын I-р байр

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул

Нэгдсэн Үндэстний гудамж Улаанбаатар хот

дүүргийн I хороо, Чингисийн өргөн чөлөө, Шинэ Зууны байр

Монгол Улс

Факс: +976 [11-327914]

Факс: +976 [70112038]

Эдийн засгийн хөгжлийн яаманд

Ерөнхий захиралд

- 10.6.2. Талууд гэрээний 10.6.1-д заасан хаяг, утас, факсын дугаар болон электрон шуудангийн хаягаа өөрчлөх тохиолдолд өөрчлөхөөс 14 /арван дөрөв/-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа урьдчилан бичгээр мэдэгдэнэ.
- 10.6.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх бол хүлээн авсаныг нотолж хүлээлгэн өгч буй талын баримт бичигт хүлээн авагч талын хүлээн авсан этгээд гарын үсэг зурсанаар мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.
- 10.6.4. Мэдэгдлийг буухиа шуудангаар хүргүүлэх бол буухиа шуудангийн хүлээлгэн өгсөн баримтад хүлээн авагч тал гарын үсэг зурсанаар мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно. Буухиа шуудангийн үйлчилгээ ямар нэг байдлаар саатсан тохиолдолд буухиа, электрон шуудангаар илгээсэн мэдэгдлийг биечлэн эсхүл факсаар дамжуулан хүргүүлнэ.
- 10.6.5. Мэдэгдлийг факсаар хүргүүлэх бол факсын төхөөрөмжөөс факсын илгээмжийг амжилттай илгээсэн гэсэн хуудас хэвлэгдсэнээр мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.
- 10.6.6. Мэдэгдлийг электрон шуудангаар хүргүүлэх бол хүлээн авагч тал илгээгч талд электрон шууданг хүлээн авсныг хариу электрон шуудангаар мэдэгдсэнээр мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.
- 10.6.7. Мэдэгдлийг хүлээн авсан өдрийг хүлээн авагч талын хүлээн авсан ажлын өдрөөр тодорхойлно.

10.7. Бусад зүйл

10.7.1. Гэрээг байгуулахтай холбогдсон зардлыг талууд тус тусдаа хариуцна.

10.7.2. Энэ Гэрээний ямар нэг нөхцөл, заалт, эрх үүргийг аль нэг тал биелүүлээгүй бол энэ нь гэрээнээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд

мөн тэдгээрийг зөрчсөн зөрчилд тохирох арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлэх аль нэг талын эрхэд сэргөөр нөлөөлөхгүй.

- 10.7.3. Гэрээ нь талуудын хооронд ямар нэгэн нөхөрлөл эсхүл хамтарсан компани байгуулах зорилгыг агуулаагүй бөгөөд аль нэг тал нөгөө талынхаа нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр байгуулах, баталгаа гаргах, түүнийг төлөөлөхийг хориглоно.
- 10.7.4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ гэрээ нь талуудын хоорондын бүх тохиролцоог илэрхийлсэн үндсэн баримт бичиг болох бөгөөд талуудын гэрээг байгуулахаас өмнө энэ Гэрээний зохицуулах зүйлийн талаар хийсэн аман тохиролцоо, мэдэгдэл, хэлэлцээр, ойлголтыг гэрээ бүрэн орлоно.
- 10.7.5. Гэрээг Монгол хэл дээр 3 /гурван/ хувийг үйлдэнэ. Хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна. Гэрээг үл хөдлөх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж хадгална.

Талууд энэхүү гэрээнд 2013 оны 06 сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

КОНЦЕСС ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД Н. БАТБАЯР

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ШИНЭ АЗИА ГРУПП ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л. ТӨРБАЯР